

Ерөнхий мэргэжлийн эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил

Хувилбар -12

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
 2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
 - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
 3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (A.)
 - Зөв, Зөв, Буруу (B.)
 - Зөв, Буруу, Буруу (C.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)
- /1./ Зүүн уушгины доод хилийг олохдоо ямар шугамаар тогших вэ?
- A. Өвчүүний ойролцоох
 - B. Эгэмний дунд
 - C. Суганы \урд, дунд, ард\
 - D. Далны
 - E. Нурууны ойролцоох
- /2./ Мантугийн сорилыг тавихдаа туберкулиныг яаж хэрэглэх вэ?
- A. Цагаан мөгөөрсөн хоолойд цацна
 - B. Арьсанд тарина
 - C. Арьсан дор тарина
 - D. Судсанд тарина
 - E. Арьсан дээр хэрэглэнэ
- /3./ Анафилаксийн үед медиаторууд ямар эсээс ялгарах вэ?
- A. Эозинофил
 - B. Т-лимфоцит
 - C. Цулцангийн макрофаг
 - D. В-лимфоцит
 - E. Хөөнгө эс
- /4./ Дараахаас аль нь үнэн бэ?
- A. Уушгины архаг бөглөрөлт өвчний үед ингаляцийн кортикостероиддыг дангаар удаан үйлдэлтэй гуурсан хоолой тэлэгч эмгүй\хэрэглэхийг зөвлөхгүй
 - B. Ингаляцийн кортикостероидыг FEV1 \geq 80% өвчтөнд хэрэглэнэ
 - C. Хүндэвтэр зэргийн уушгины архаг бөглөрөлт өвчинтэй хүнд удаан хугацааны туршид системийн кортикостероид хэрэглэнэ
 - D. Уушгины архаг бөглөрөлт өвчний сэдрэлийн үед кортикостероидыг хэрэглэхгүй
 - E. Уушгины архаг бөглөрөлт өвчний үед ингаляцийн кортикостероидыг аль болох эрт хэрэглэнэ
- /5./ Гялтангийн шингэнд ямар эс давамгайлах тохиолдолд хурц үрэвслийн тухай бодож болох вэ?
- A. Лимфоцит
 - B. Эозинофил
 - C. Нейтрофил
 - D. Эритроцит
 - E. Моноцит

- /6./ Уушгины дэлбэнгийн үрэвслийн үед ямар шинж тодорхойлогдох вэ?
1. Амьсгал эрс сулрах, эсвэл сонсогдохгүй байх
 2. Бронхофони ба дууны доргион ихсэх
 3. Тогшиход хэргэргэн дуутай байх
 4. Гуурсан хоолойн амьсгал сонсогдох
 5. Бронхофони ба дууны доргион сулрах
- /7./ Гуурсан хоолой тэлэгдэх өвчний эмчилгээний үндсэн аргыг нэрлэнэ үү:
1. Байрлалын дренаж
 2. Хордлого тайлах
 3. Доргионт массаж
 4. Дархлаа дэмжих
 5. Цэр шингэлэх
- /8./ Цээжний хөндийн хоёр талын лимфаденопати ямар өвчний үед илэрч болох вэ?
1. Саркоидоз
 2. Лимфогранулематоз
 3. Лимфом
 4. Гистиоцитоз Х
 5. Силикоз
- /9./ Уушгины сүрьеэ үүсэхэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл бол:
1. Ходоод, дээд гэдэсний шархлаа
 2. Чихрийн шижин
 3. Силикоз
 4. Лимфогранулематоз
 5. Артерийн гипертензи
- /10./ Дараахаас аль нь уушгины архаг бөглөрөлт өвчний хүнд сэдрэл үүсэх эрсдлийг нэмэгдүүлэх вэ?
1. Өндөр настай байх
 2. Хавсарсан өвчин эмгэгтэй байх
 3. Өвчин удаан хугацаанд үргэлжлэх
 4. Цэртэй ханиалгах
 5. Амьсгаадалт нэмэгдэх
- /11./ Гликокаликс гэж аль ойлголтыг нэрэлдэг вэ
- A. Подоцитийн элемент
 - B. Мезангиумын элемент
 - C. Суурин мембраны хасах цэнэгтэй хэсгүүд
 - D. Ялгаруулах аппарат
 - E. Ренин
- /12./ Хоёрдогч пиелонефритийн үед доорхи шинжүүдээс нэгээс бусад нь илрэнэ
- A. Дизури
 - B. 1мл шээсэнд 100000-аас дээш нян илэрнэ
 - C. Бөөрний аяганцар тэвшинцэрийн деформаци
 - D. Түүдгэнцэрийн шүүлт буурах
 - E. Сувганцаэрын эргэн шимэгдэлт буурах
- /13./ Архаг гломерулонефритийн даралт ихдэх хэлбэрийн сэдрэлийн үед дараах нэг шинжээс бусад нь илэрнэ.
- A. Протеинури
 - B. Гематури
 - C. Цилиндрури
 - D. Хаван
 - E. Артерийн даралт ихсэлт
- /14./ Доплерт сонографи дараахь тохиолдлоос нэгээс бусдад хийх шаардлагатай.
- A. Бөөрний хавдар
 - B. Шалтгаан тодорхойгүй шээс цустах
 - C. Шалтгаан тодорхойгүй даралт ихсэх
 - D. Архаг гломерулонефрит

- Е. Бөөрний унжилт
- /15./ Шээсний шинжилгээнд ямар төрлийн бортгонцор илэрвэл хэвийн гэж үзэх вэ?
- А. Гиалин
 - В. Зернистый
 - С. Восковидный
 - Д. Эритроцитын
 - Е. Лейкоцитын
- /16./ Архаг гломерулонефритийн үед гормон эмчилгээ хийх заалт
1. Гематури
 2. Артерийн даралт ихсэлт
 3. Бөөрний архаг дутагдал
 4. Нефроз хам шинж
 5. Сэдрэлээс сэргийлэх зорилгоор
- /17./ Транзитор уураг алдалт нь дараах тохиолдолд илрэнэ
1. Биеийн эмгэг галбир
 2. Даарч хөрөх
 3. Биеийн хүчний хүнд ажил хийх
 4. Удаан хугацаагаар халуурах
 5. Фитнес хийх
- /18./ Бөөрний цочмог дутагдалын үед зайлшгүй хийх лабораторын шинжилгээ
1. Шээсний нянгийн шинжилгээ
 2. Цусан дах креатинины хэмжээ
 3. Нүдний уг дурандах
 4. Цусны электролит үзэх
 5. Цусны PH үзэх
- /19./ БАӨ-ий үед MDRD –аар ТШХ тодорхойлоход хэрэглэгдэхгүй үзүүлэлт аль вэ?
1. Сийвэнгийн креатинин
 2. Биеийн жин
 3. Нас
 4. Креатинины клиренс
 5. Хүйс
- /20./ Пиелонефритийн хамгийн түгээмэл тохиолдох үүсгэгч нь аль вэ?
1. Стрептококк
 2. Клебсиелл
 3. Бактерууд
 4. Гэдэсний савханцар
 5. Вирусууд

/21./ БАӨ-өөр өвдөх эрсдэл өндөртэй хүмүүсийг илрүүлэн хянах нь чухал. Хянахдаа 12 сард 1 удаа хяналтын үзлэг хийхийн зэрэгцээ жилд 2-3 удаа хэвтүүлж эмчилснээр БАӨ-г сэргийлэх боломжтой болдог.

/22./ шээсэнд 3 Сар ба түүнээс удаан хугацаанд уураг илэрсэн тохиолдолд Бөөрний архаг өвчинг оношлоно. Иймд Бөөрний архаг өвчинг шээсэн дэхь уургийн хэмжээгээр нь 2 үе шат болгон ангилдаг.

/23./ Асцитийн шингэнд нейтрофил эсийн тоо >250 мм³ тохиолдолд ямар эмгэгийг сэжиглэх вэ?

- А. Сүрьеэгийн шалтгаантай асцит
 - В. Хавдарын шалтгаантай асцит
 - С. Аяндаа үүсэх перитонит
 - Д. Зүрхний дутагдлын шалтгаантай асцит
 - Е. Элэгний циррозын шалтгаантай асцит
- /24./ Бүдүүн гэдсэнд оршин биед ашигтай нянгийн төлөөлөгч
- А. Бифидумбактер, лактобактер, гэдэсний савханцар, энтеркокк

- В. Агааргүйтэн нян 99%, агаартан нян 1%-ийг эзэлдэг
С. Гэдэсний савханцар тэргүүтэй агаартан нян давамгайлна
- /25./ D хепатитийн вирус нь дараах вирусгаар халдварлагдсан үед элэгний эсэд нэвтрэн элгийг үрэвсүүлнэ:
А. Вирус А
В. Вирус С
С. Вирус В
- /26./ Элгэнд аммиак холбогдон хувирахыг идэвхжүүлэх үйлдэлтэй эмийг сонгоно уу?
А. Эссенциаль
В. Гептрал
С. Гепта-мерз
D. Гемодез
Е. Неоминопагин
- /27./ Цэсний сөөргөөт гастритын үед амьд сорьцын эмгэг бүтцийн шинжилгээнд ямар өөрчлөлт гарах вэ?
А. Үрэвслийн эсийн нэвчдэс, шалбархай, өнгөц шарх, эсийн гэмтэл
В. Салстын дорх цус харвалт, эсийн гэмтэл, лимфоцит эсийн нэвчдэс
С. Хонхорхойн гиперплази, ходоодны өөрийн ялтас хөөсөн, цус дүүрсэн, лимфоцит, плазмоцит, лаброцит эсийн нэвчдэс
D. Хонхорхойн гиперплази, шалбархай, өнгөц шарх, эсийн гэмтэл
Е. Эсүүд хөөсөн, гэдэсний метапази, хатингаршил
- /28./ Цэс нойр булчирхайн сувгийг сэтгүүрдэх шинжилгээний хүндрэл
1. Цус алдалт
2. Ретроперитониал-дуоденал цооролт
3. Сепсис
4. Панкреатит
5. Амьсгал зүрх судасны хямрал
- /29./ Гистамины H2 рецепторыг хориглогч 3-р үеийн эмийн бэлдмэлийг сонгоно уу?
1. Цемитидин
2. Ранитидин
3. Зантак
4. Фамотидин
5. Роксатидин
- /30./ Литотрипси хийсний дараа ямар хүндрэл гарах вэ?
1. Цэсний ерөнхий цорго гэмтэх
2. Транзитор цэсний хатгаа
3. Цэсний ерөнхий сорвижих
4. Панкреатит
5. Цэсний хүүдий цоорох
- /31./ Нойр булчирхайн цочмог үрэвслийн үед эрт илрэх, хүндрэл аль нь вэ?
1. Уушигны гялтанд шингэн хурах
2. Чихрийн шижин
3. Буглаа
4. Нойр булчирхайд хуурамч уйланхай үүсэх
5. Элэгний дутагдал
- /32./ Суулгалт зогсоох үйлчилгээт эмийг сонгоно уу?
1. трихопол
2. сульфасалазин
3. фестал
4. имодиум
5. метоклопрамид

/33./ Дээд гэдэсний дамжуулалт алдагдах нь нугалуурын клапан, том хөхлөгийн агшилт үүсгэх учир дээд гэдэсний агуулагдахуун эргээд цэсний зам руу хаягдан халдвар орох нөхцлийг бүрдүүлж халдварын гаралтай холецистит үүснэ

/34./ Ходоод, дээд гэдэсний шархлаа өвчний үндсэн шалтгаан нь хеликобактер пилори юм. Яагаад гэвэл ходоод, дээд гэдэсний салстын хамгаалах хүчин зүйл, гэмтээх хүчин зүйл хоёрын тэнцвэрт байдал алдагдан гэмтээгч хүчин зүйлийн үйлчлэлээр ходоод дээд гэдэсний салстад шархлаа үүсдэг

/35./ Гипогликемийн комын үед дараах тохиолдолд тархи хавагнасан гэж үзнэ.

- A. Таталт илэрвэл
- B. Дэмийрч солиорвол
- C. Хүүхэн хараа өргөсвөл
- D. Цусны глюкоз 6.0 ммоль/л хүртэл өссөн боловч ухаан орохгүй бол
- E. Цусны глюкоз 3.0 ммоль/л-ээс их болсон ч ухаан сэргэхгүй бол

/36./ Тархмал хордлогот бахуугийн үед зүрх судасны талаас илрэх эмнэлзүйн шинжийг сонгоно уу

- A. Артерийн даралт багасах
- B. Зүрхний хэм алдагдал
- C. Атеросклероз
- D. Перикардийн хөндийд шингэн хуримтлагдах
- E. Тиреотоксикозын миопати

/37./ Глюкагон дараах үйлдэлтэй.

- A. Липолизыг багасгана
- B. Гексокиназа ферментийн үйл ажиллагааг идэвхижүүлнэ
- C. Гликогенезийг ихэсгэнэ
- D. Глюконеогенезийг багасгана
- E. Гликогенолизыг ихэсгэнэ

/38./ Таргалалтын эмчилгээг сонгоно уу

- A. Хоол эмчилгээ
- B. Хөдөлгөөн эмчилгээ
- C. Эмийн эмчилгээ
- D. Мэс заслын эмчилгээ
- E. Дээрх бүгд орно

/39./ Гипокортицизмын шалтгааныг нэрлэ

- A. Гүйлгэх
- B. Сүрьеэ
- C. Өндгөвчний хавдар
- D. Олигоменоррей
- E. Глюкокортикостерома

/40./ 2-р хэлбэрийн ЧШ-ий шалтгаан

1. Удам зүйн урьдчилсан байдал: HLA B15, DR4, DRw4, DQB1*0302, DQA1*0301
2. Вирус: Коксаки В4, улаанууд, паротит
3. Удам зүйн урьдчилсан байдал: HLAB8, DRw3, DQB1*0201, DQA1*0501
4. Удам зүйн урьдчилсан байдал: HLA-тэй холбоогүй
5. β эс ба арлын эсрэг антител үүсэх

/41./ Гипогликемийн комын үед авах арга хэмжээнд аль нь орохгүй вэ

1. Нүүрс усаар баялаг хоол идүүлнэ
2. Глюкагон 0.5-1.0мл булчинд тарина
3. Глюкозын 5%-н 200-400мл уусмал дуслаар судсанд хийнэ
4. Глюкозын 40%-н 60-80мл уусмал судсанд тарина
5. Глюкозын 20%-н 200мл уусмал дуслаар судсанд хийнэ

/42./ Аддиссоны өвчний үед артерийн даралт буурна. Яагаад гэвэл Аддиссоны өвчний үед альдостерон дутагдсанаас гиперволеми болдог.

/43./ Анхдагч артерийн гипертензийн үед ЗЦБ –р илрэх зүүн ховдлын томролын Лион-Соколовын шинж тэмдэгийг заах

- A. $Rv5 > 25\text{мм}$
- B. $Sv3 + Rv1 > 24\text{ мм}$
- C. $Rv4 > Rv5$
- D. $Rv5 + Sv1 > 30\text{мм}$
- E. $Rv5 + Sv1 > 35\text{мм}$

/44./ ЗЦШ-ийн үед чагнахад хоёр уушгины арын доод хэсгээр нойтон хэрчигнүүр сонсогдож байвал зүрхний цочмог дутагдлын (Киллипин ангилалаар) хэд дүгээр зэрэг байж болох вэ?

- A. I зэрэг
- B. II зэрэг
- C. III зэрэг
- D. IV зэрэг
- E. V зэрэг

/45./ Дараах оношлогооны аргуудаас аль нь миокардын ишемийг эрт оношлох боломжтой вэ?

- A. Зүрхний цахилгаан бичлэг
- B. Зүрхний хэт авиан шинжилгээ
- C. Анамнез
- D. Зүрхний ачаалалтай бичлэг
- E. Сийвэнд фермент үзэх

/46./ Эмнэл зүйн ямар хэлбэрийн перикардитийн үед цээжний өвдөлт ба перикардын шүргэлцэх чимээ илэрдэг вэ?

- A. Цочмог перикардит
- B. Хуурай перикардит
- C. Шүүдэст цочмог перикардит
- D. Шүүдэст архаг перикардит
- E. Наалдаст перикарди

/47./ Гипертензийн кризын үед АД-н түвшинг эхний 2 цагт хэдэн хувиар бууруулвал тохиромжтой вэ?

- A. 20%-р
- B. 35%-р
- C. 10%-р
- D. 15%-р
- E. 25%-р

/48./ Ямар хүмүүс халдварт эндокардит өвчинд өртөмтхий вэ?

1. Хиймэл хавхлага суулгасан
2. Хар тамхи хэрэглэдэг
3. Гемодиализ хийлгэдэг
4. Митрал хавхлагын унжилттай
5. Гүйлсэн булирхайн үрэвсэлтэй

/49./ Зүрх судасны өвчний ерөнхий эрсдлийг тодорхойлохын тулд танд ямар мэдээлэл хэрэгтэй вэ?

1. Артерийн даралтын түвшин
2. Цусан дахь холестрины хэмжээ
3. Цусан дахь глюкозын хэмжээ
4. Тамхи татдаг эсэх
5. Нас

/50./ Фраксипарин гепаринаас ямар давуу талтай вэ?

1. Илүү удаан үйлчилгээтэй
2. Хэрэглэхэд хялбар
3. Цус бүлэгнэлтийг үзүүлэлтийг хянах шаардлагагүй
4. Хямд
5. Тромбоцитопени үүсгэхгүй

/51./ Зүрхний цочмог шигдээсийн эмчилгээтэй холбоотой зөв хариултыг сонгоно уу?

1. Амь насанд аюултай хэм алдагдлаас сэргийлэх зорилгоор лидокайн тарих нь үр дүнтэй
2. Эмчилгээнд нифедипин хэрэглэхэд нас барах эрсдэл ихэсдэг

3. Курантил нь шигдээс дахилтыг бууруулдаг
 4. Эмчилгээний үр дүн нь оношлосон хугацаанаас шууд хамааралтай
 5. Бүлэн уусгах эмчилгээг эхний 24 цагт хийвэл үр дүнтэй
- /52./ Митрал хавхлагын нарийслын үед зүрхний цахилгаан бичлэгт илэрдэг өөрчлөлтийг сонгох
1. Тосгуурын мерцани
 2. Зүүн ховдлын томрол
 3. Зүүн тосгуурын томрол
 4. Гисийн баруун салааны хориг
 5. Цахилгаан тэнхлэг зүүн тийш хазайна
- /53./ Зүрхний шигдээсийн дараа зүүн ховдолд бүлэн үүсдэг. Энэхүү тохиолдолд варфарин хэрэглэдэг.
- /54./ Нугасны усны шинжилгээнд ямар өөрчлөлт илэрвэл Нейролейкеми гэж үзэх вэ?
- A. 1 мкл нугасны усанд 20-с дээш цитоз илэрвэл
 - B. Нугасны усанд Пандийн урвал эерэг гарвал
 - C. 1 мкл нугасны усанд 10-с дээш цитоз илэрвэл
 - D. Нугасны усанд цусны дүрст элементүүд орж ирсэн байвал
 - E. Нугасны ус даралт ихтэй, өнгөн нь өөрчлөгдсөн байвал
- /55./ Идиопатик тромбоцитопенийн үед дараахь шинжийн аль нь илрэхгүй вэ?
- A. Дэлүү авах нь үр дүнтэй
 - B. Ясны хэмэнд мегакариоцитын тоо ихсэнэ
 - C. Ig G –н титр ихсэнэ
 - D. Панцитопени илрэнэ
 - E. Тромбоцит хэмжээгээр томорно
- /56./ Цочмог миелобластын лейкокийн /ЦМЛ/ оношлогооны гол үзүүлэлт юу вэ?
- A. Миелограммд илрэх бластын тоо 20%-иас их байх
 - B. Өмнө нь Вит В12 дутагдлын цус багадалт оношлогдож байсан өвчтөн
 - C. Захын цусны түрхэцэнд илрэх бластын тоог 15%-иас их байх
 - D. Цитогенетикт Ph хромосом илэрсэн байх
 - E. Лейкограммд цагаан эсийн зүүний хазайлт илрэх
- /57./ Глюкоз-6-фосфатдегидрогеназын дутагдал илэрхий хурц явагддаг хэлбэрийг юу гэж нэрлэдэг вэ?
- A. Фавизм
 - B. Г-6-фосфатдегидрогеназапати
 - C. Вальденстромын өвчин
 - D. Плейхроми
 - E. Маркиав- Микелийн өвчин
- /58./ Төмөр дутагдлын үеийн цус төлжилтийн үеийг сонгоно уу?
- A. Төмөр дутагдлын цус багадалтын үеийн эмнэлзүй, лабораторын шинж илрэх үе
 - B. Сийвэнгийн Fe багасаж, гемоглобин хэвийн байх
 - C. Сийвэнгийн ферритин багасаж, Fe, гемоглобин хэвийн байх
 - D. Сийвэнгийн ферритин багасаж, төмөр ихсэх
 - E. Сийвэнгийн төмөр ихсэж, ферритин ихсэх
- /59./ Доорх өөрчлөлтүүдээс аль нь архаг миелолойкозын даамжралын шатанд орсныг илтгэх вэ?
1. Даамжирсан тромбоцитоз
 2. Хромосомын нэмэлт гаж өөрчлөлтүүд илрэх
 3. Ясны улаан чөмөгний эсийн шинжилгээнд бласт эсийн тоо ихсэх (≥ 10) шинжилгээнд
 4. Трепанобиопси-д өөхний эсүүд ихээр илрэх
 5. Лейкоцитийн тоо ихэвчлэн 150 мянгаас дээш болох
- /60./ Архаг өвчний үеийн цус багадалт нь цус багадалтын бие даасан хэлбэр бөгөөд дараах эмгэг жамын хүчин зүйлс чухал үүрэгтэй

1. Ясны чөмөгний макрофагуудын доторх төмөр улаан эсийн үүсэлд ашиглагдахгүй болж, эритропоэтины ялгарал багасна

2. Ясны чөмгөн дэх эритрокариоцитын эсрэг эсрэг бие үүснэ

3. Ясны чөмөг эритропоэтинд хариулах чадвар буурч, улаан эсийн үүсэлт цитокинүүдээр дарангуйлагдана

4. Улаан эсийн мембраны гажиг хавсран илэрнэ

5. Гемоглобины нийлэгжилт алдагдана

/61./ Ургийн нуруулалт гэдэг нь:

A. Ургийн нуруу эхийн хажуу хана руу харьцаж байрласан

B. Ургийн нуруу эхийн урд хана руу харьцаж байрласан

C. Ургийн нуруу ард хана руу харьцаж байрласан

D. Ургийн нуруу эхийн умайн дагуу тэнхлэгт харьцаж байрласан

E. Ургийн нуруу умайтай хурц өнцөг үүсгэж харьцаж байрласан

/62./ Жирэмсний 36-37 хоногтойд ураг орчмын шингэн гарч 7 цаг болж байгаа, төрөх зам төрөлтөнд бэлтгэгдсэн, халдварын болон ураг бүтэлтийн шинж тэмдэг илрээгүй. Төрөлтийг яаж шийдвэрлэх вэ?

A. Кесар хагалгаагаар төрүүлнэ

B. Төрөлтийг идэвхитэй удирдаж төрүүлнэ

C. Хүлээх тактик баримталж төрүүлнэ

D. Хяналтанд байлгана

E. Хавчуур тавина

/63./ Биений юмны хэвийн мөчлөгийн үед умайн салстын зузаарал хэдийд гүйцэх вэ?

A. Мөчлөгийн 25-26 дэх хоногтойд

B. Мөчлөгийн 14-15 дахь хоногтойд

C. Мөчлөгийн 18-20 дахь хоногтойд

D. Мөчлөгийн 9-11 дахь хоногтойд

E. Мөчлөгийн 7-8 дахь хоногт

/64./ Хүнд хэлбэрийн цус багадалттай жирэмсэн эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?

1. Цус сэлбэх боломжтой газар төрүүлнэ

2. Төмрийн бэлдмэлийг 2 шахмалаар 3 сар уулгана

3. Эмнэлэгт яаралтай шилжүүлнэ

4. Яаралтай төрүүлнэ

5. Хэврийн дэглэмд байлгана

/65./ Эмнэлэг хүрэх замд төрлөг явагдана гэж үзвэл юу бэлдсэн байх ёстой вэ?

1. Саван, гар угаах ус

2. Төрлөгийн нэг удаагийн тусламжийн хэрэгсэл /ир, 3 боолт/

3. Хүүхдийг эх барих, хатаах, өлгийдөх цэвэр даавуу /3/, хүүхдийн цэвэр хувцас.

4. Ихэс хийх пластик хүүдий.

5. Хүүхдэд зориулсан сэхээн амьдруулах амавч, хүүдий.

/66./ Жирэмслэхээс хамгаалах дааврын хавсарсан эмийг хэзээ хэрэглэх вэ?

1. Биений юмны дунд үед

2. Биений юм ирсэн 7 дахь өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.

3. 12 долоо хоног буюу 3 сар тутам нэг удаа булчинд тарина

4. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна

5. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол

/67./ Улаан хоолойн цүлхэнгийн аль тохиолдлыг нь мэс заслаар эмчлэх вэ?

A. Цүлхэн нь илэрхий

B. Цүлхэн улаан хоолойн хүзүүн хэсэгт байрласан+хахаж цацах

C. Цүлхэн нь улаан хоолойн цээжний хэсэгт + цүлхэн нь өрцөн дээр байрласан

D. Хахаж цацах + улаан хоолой агчих + цүлхэнд контраст удаанаар саатах

E. Цүлхэн улаан хоолойн цээжний хэсэгт байрласан + цүлхэн нь өрцний дээр байрласан + хахаж цацах

/68./ Химийн түлэгдэл авснаас хойш 1-2 долоо хоногийн дараагаар улаан хоолойг хэр олон удаа сэтгүүрдэх вэ?

A. Өдөрт 3 удаа

- B. Өдөрт 2 удаа
 - C. Өдөр бүр
 - D. Өдөр өнжөөд
 - E. Гурван хоногт 1 удаа
- /69./ Наалдац нь ямар эдээр үүсдэг вэ?
- A. Сийрэг холбогч эдээр үүссэн
 - B. Булчинлаг эдээр үүссэн
 - C. Судасны холбогч эдээр үүссэн
 - D. Судасгүй холбогч эдээр үүссэн
 - E. Холбогч эдгүй үүссэн
- /70./ Өвчтөнөөс эмчид халдвар дамжих үйл явцад хамаарахгүй хүчин зүйлийг нэрлэнэ үү?
- A. Өвчтөн халдвар үүсгэгч нян, вирустай байх
 - B. Өвчтөний цус, шингэн эмчийн биед нэвтрэх зам байх
 - C. Өвчтөн эмгэг өвчнөөр халдварлагдсан өгүүлэмж
 - D. Эмчийн биед халдвар үүсгэхүйц олон тооны нян нэвтэрч орох
 - E. Эмчийн дархлаа сул байх
- /71./ Гэмтсэн өвчтөнийг шаардлаггүй үед хөдөлгөж, зөөхөд ямар сөрөг нөлөө гарч болох вэ?
- 1. Хугарсан яс арьсийг цоолох
 - 2. Хугарсан яс зөөлөн эд, судас гэмтээх
 - 3. Цус алдалтыг нэмэгдүүлэх
 - 4. Шарханд халдвар орох
 - 5. Өвдөлт нэмэгдүүлэх
- /72./ Удаан үйлчилгээтэй 30 мг-ын Морфиныг 12 цагаар хоногт 2 удаа ууж байгаад өвдөлтгүй болсон өвчтөний удаан үйлчилгээтэй уудаг Морфин тасарсан тул түүнд богино үйлчилгээтэй 10 мг-ын Морфиныг яаж өгөх вэ?
- A. Богино үйлчилгээтэй 10 мг-ын Морфиныг 3 шахмалаар 12 цагаар уулгах
 - B. Богино үйлчилгээтэй 10 мг-ын Морфиныг 10 мг-аар 4 цагаар 6 удаа уулгах
 - C. Богино үйлчилгээтэй 10 мг-ын Морфиныг 2 шахмалаар 3 удаа 8 цагаар уулгах
 - D. Богино үйлчилгээтэй 10 мг-ын Морфиныг 2 шахмалаар 12 цагаар уулгах
 - E. Богино үйлчилгээтэй 10 мг-ын Морфиныг 6 шахмалаар хоногт нэг удаа уулгах
- /73./ Церукал бөөлжилтийн эсрэг ямар эмийн бүлэгт хамрагдах вэ?
- 1. Хеморецепторт сул үйлчилдэг тул бөөлжилтийг намдаадаг
 - 2. Бөөлжилтийн төвийг дарангуйлах үйлчилгээтэй
 - 3. Ходоод, 12 хуруу гэдсийг доош нь гөрвөлзүүлдэг гастрокинетик үйлчилгээтэй
 - 4. Тэнцвэрийн төвийг дарангуйлах үйлчилгээтэй
 - 5. Ходоодны салстыг хамгаалах үйлчилгээтэй
- /74./ Сегментын хэвшинжийн мэдрэхүйн өөрчлөлт
- A. Нугасны арын эвэр
 - B. Нугасны өмнөд эвэр
 - C. Нугасны хажуу эвэр
 - D. Ganglion spinal
 - E. Premotor cortex
- /75./ Настантай харилцах онцлогийг дурьдана уу?
- 1. Анхааралтай сонсож харилцах
 - 2. Үнэт зүйлсийг нь хүндэтгэх
 - 3. Сэтгэл хөдлөлийг мэдэрч харилцах
 - 4. Хөгжөөх, тоглох
 - 5. Асран хамгаалагчаар нь дамжуулан харилцах
- /76./ Уушгины голомтот өөрчлөлт идэвхитэй байгаа тохиолдолд тодрол нь ямар байх вэ?
- A. Бага буюу сул
 - B. Янз бүрийн
 - C. Өндөр
 - D. Дунд зэрэг
 - E. Дээрхи бүгд

/77./ Сүрьеэгийн нян илрүүлэх цэрний түрхэцийг Циль-Нильсены аргаар будах үед сүрьеэгийн савханцарын ямар шинжийг ашиглаж байна вэ?

- A. Гадаад орчинд тэсвэртэй шинж
- B. Хүчилд тэсвэртэй шинж
- C. Сөрөг хэмд тэсвэртэй шинж
- D. Хувирамтгай шинж
- E. Дээрхи бүгд

/78./ Туберкулем даамжирч, задарсан тохиолдолд илрэх шинжүүдийг тоочно уу?

- 1. Цэртэй ханиах, цустай ханиах
- 2. Хордлогын хам шинж тод илрэх
- 3. Цэрний түрхэц эерэг гарах
- 4. Цусны шинжилгээнд өөрчлөлт илэрч,СОЭ хурдсах
- 5. Гэрлийн шинжилгээнд гэмтэлийн хэмжээ томорч, сүүдэр жигд бус болох

/79./ Уушигны сүрьеэгийн сэжигтэй шинж тэмдэгүүдийг тоочно уу?

- 1. 21 хоногоос дээш хугацаанд ханиах
- 2. Цэр, цустай цэртэй ханиах
- 3. Цээжээр өвдөх
- 4. Халуурах, хөлрөх
- 5. Турах

/80./ Дельта вирүсийн үүсгэгчийг тэмдэглэ.

- A. ДНХ агуулсан гепаднавирүс
- B. РНХ агуулсан флавивирүс
- C. РНХ агуулсан калцивирүс
- D. РНХ агуулсан согогтой вирүс
- E. РНХ агуулсан ортомиковирүс

/81./ Тархины цочмог хавангийн 3-р зэргийн үед цусны рСО₂-ийн хэмжээ дараахь байдалтай байна.

- A. Хэвийн
- B. Багасана
- C. Ихэсэнэ
- D. Янз бүрийн хэмжээнд
- E. Хэт багасна.

/82./ Цочмог цусан суулгын колитын хэлбэрийн үед ямар шинжүүд илрэх вэ?

- 1. Өвчний эхлэл хурц
- 2. Хий дүлнэ
- 3. Хэвлийн доод хэсгээр базалж өвдөнө
- 4. Ус ихтэй суулгана
- 5. Маш их хөстэй

/83./ Урвах тахлын эгэл бус хэлбэрүүдийг тэмдэглэ.

- 1. Өндөр настай хүмүүст
- 2. Хуурай хэлбэр
- 3. Жирэмсэн эмэгтэйд
- 4. Цахилгаан хэлбэр
- 5. Бага насны хүүхдэд

/84./ Нүдний дотоод шингэн хаанаас үүсдэг вэ?

- A. Болорын арын капсулаас
- B. Сормосовчийн сэртэнгээс
- C. Шиллэг биеээс
- D. Хүүхэн харааны дотно ирмэгээс
- E. Шүдлэг зурваснаас

/85./ Аль нүдний гидродинамикийн үзүүлэлт вэ?

- 1. Шингэний үүсэн гарах хурд
- 2. Нүдний дотоод даралт
- 3. Нүднээс урсан гарах хурд
- 4. Урсгалын даралт

5. Нүдний шингэний 1 минутын хэмжээ
- /86./ Харааны мэдрүүлийн хаван үүсгэсэн шалтгаанаас хамааран хэрхэн ангилдаг вэ?
1. Анхдагч
 2. Халдварын
 3. Хоёрдогч
 4. Харшлын
 5. Удамшлын
- /87./ 0-1 насны хүүхдийн чихийг шинжлэх хамгийн тохиромжтой рентген шинжилгээ аль нь вэ?
- A. Шюллерийн арга
 - B. Майерийн арга
 - C. Стенверсийн арга
 - D. Гинзбургийн арга
 - E. КТ
- /88./ Хамрын харшил илрүүлэх сорилын хэлбэрүүдийг нэрлэнэ үү
1. Хамрын хөндийн сорил
 2. Арьсан дээрхи сорил
 3. Арьсан доорхи сорил
 4. Хэлний доор дусааж сорил хийх
 5. Нүдэнд дусааж сорил хийх
- /89./ Хамрын үзүүр, угалз хэсгийн тосны булчирхайн цорго битүүрч, батга өтгөрч, орчны цусны хялгасан судсууд холбогч эдтэй наалдан, хамар хэмжээгээрээ томрох эмгэгийг “боргоцой хамар” гэх (1) бөгөөд үүнийг зөвхөн мэс заслаар л эмчилнэ
- /90./ 62 настай малчин эмэгтэй баруун өвдөг рүү хатгуулж өвддөг болсон зовиуртай. Өвдөг ялангуяа шөнийн цагаар их өвддөг. Тэр мал төл авах, хонь түрүүлэх ажил хийдэг ба бээлийгүй гараараа зулбасан малын эхэс хуулдаг байсан гэв. Түүний ээж 78 настайдаа нугасанд сүрьеэгийн хүйтэн буглаатай, өвдөгний сүрьеэтэй байгаад ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасагт 10 жилийн өмнө нас барсан. Нөхөр нь булчирхайн сүрьеэгээр өвчилж, хүзүүний булчирхайнаас идээрхэг шингэн гойжсон тул мэс засал хийлгэж, булчирхайг авахуулсан. Эмэгтэй өөрөө туранхай, хөлрөмтгий, ядрамтгай. Рентген зурагт баруун өвдөгний яс голомтот эмтэрсэн өөрчлөлттэй, зүүн өвдөг остеоартритын шинжтэй. Түүнд ямар эмчилгээ илүү үр дүнтэй вэ?
- A. Антибиотик
 - B. Даавар эмчилгээ
 - C. Сүрьеэгийн эсрэг эмчилгээ
 - D. Аллопуринол эмчилгээ
 - E. Гепарин эмчилгээ
- /91./ Настан яагаад сүү цагаан эдээ хэрэглэж байх ёстой вэ?
1. Хөгшрөлтөөс сэргийлдэг тул
 2. Сүү цагаан эдээ шингээхдээ настан илүү сайн тул
 3. Зүрхний тэтэм судасны хомсдлоос сэргийлдэг тул
 4. Кальцаар баялаг тул ясны сийрэгжилтээс сэргийлдэг тул
 5. Тархины цусан хангамжийг сайжруулдаг тул
- /92./ Настангийн үйл ажиллагааны чадварыг үнэлэхэд Карновскийн индекс 100 оноо бол юу гэж үнэлэх вэ?
- A. Эрүүл, зовиургүй, өвчний шинжгүй
 - B. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай, өвчний ганц нэг шинж илэрсэн.
 - C. Маш сул, идэвхитэй дэмжих эмчилгээ шаардлагатай
 - D. Үхлүүд, өвчин маш хурдан даамжирч байгаа
 - E. Өөрийгөө арчлах чадвар маш муу тул тусгай асаргаа шаарддаг
- /93./ Нас ахих тусам сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чадварт ямар өөрчлөлт гардаг вэ?
1. Зөвхөн сүүтэй цайгаар хоол хийж, өөр хоол идэхгүй болно

2. Гэдсэнд лактаза исэгийн дутагдал үүсдэг тул сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чадвар буурдаг
3. Настай болох тусам зөвхөн сүү уудаг болно
4. Сүү уухад суулгадаг болно
5. Хөгшчүүл хүүхэдтэй ижил түл сүүгээр л хооллох болно
- /94./ Хэрх төст үений үрэвслийн эмнэлзүйд илрэхгүй шинжийг нэрлэнэ үү.
- Шегрений хам шинж
 - Бугуйн сувагны хам шинж
 - Богтосруу ханарах
 - Хунгийн хүзүү
 - Хулсан нуруу
- /95./ Нэг үений үрэвсэлд тохирохгүйг заана уу.
- Нянгийн гаралтай үений үрэвсэл
 - Сүрьеэгийн үений үрэвсэл
 - Мөөгөнцрийн үений үрэвсэл
 - Хэрх төст үений үрэвсэл
 - Дотоод шүүрлийн шалтгаант үений үрэвсэл
- /96./ Эрхтэн тогтолцооны хатуурлын оношлогоонд ямар шинжилгээ чухал вэ:
- ANA
 - AntidsDNA
 - AntiCCP
 - ACA
 - RF
- /97./ Хэрэх өвчний үед лабораторид ямар өөрчлөлтүүд гарах вэ.
- Цагаан эс ихсэх
 - Гамма глобулин ихсэх
 - С урвалж уураг ихсэх
 - АСЛО буурах
 - Анти ССР эерэг байх
- /98./ ОА-ийн үеийн эрт үед рентгенд илрэх өөрчлөлт
- Ясны сийрэгжилт
 - Ясны ургалт байхгүй
 - Радиологийн завсар үүсэх
 - Үе хоорондын зай бага зэрэг нарийсах
 - Мөгөөрсний үхжил
- /99./ Эрхтэн тогтолцооны чонон ярын үед мэдрэлийн талаас ямар өөрчлөлт гарч болдог вэ:
- Таталт
 - Булчин хатингарших
 - Солиорол
 - Гурвалсан мэдрэлийн эмгэг
 - Миелопати, нугасны гэмтэл
- /100./ Үений үрэвслийн нөхөн төлжилтийн үед үеэр хавдах, ээрүүл хэлбэртэй болох зэрэг шинжүүд илрэх бөгөөд рентгенд үе хоорондын завсан зузаарсан байдаг.

Сорилын зөв хариулт

1-С, 2-В, 3-Е, 4-А, 5-С, 6-С, 7-В, 8-А, 9-А, 10-В, 11-С, 12-Д, 13-Д, 14-Д, 15-А, 16-Д, 17-Е, 18-С, 19-С, 20-Д, 21-В, 22-С, 23-С, 24-В, 25-С, 26-С, 27-С, 28-Е, 29-Д, 30-С, 31-В, 32-Д, 33-Д, 34-В, 35-Е, 36-В, 37-Е, 38-Е, 39-В, 40-Д, 41-В, 42-А, 43-Е, 44-В, 45-Д, 46-В, 47-Е, 48-А, 49-Е, 50-А, 51-С, 52-В, 53-А, 54-С, 55-Д, 56-А, 57-А, 58-В, 59-А, 60-В, 61-А, 62-В, 63-В, 64-А, 65-Е, 66-Д, 67-Д, 68-Е, 69-А, 70-С, 71-Е, 72-В, 73-В, 74-А, 75-Е, 76-А, 77-В, 78-Е, 79-Е, 80-Д, 81-Д, 82-А, 83-С, 84-В, 85-Е, 86-В, 87-Д, 88-А, 89-С, 90-С, 91-Д, 92-А, 93-С, 94-Е, 95-Д, 96-Д, 97-А, 98-А, 99-В, 100-А,

